



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013 - 12 - 17 № 09/85

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны 2012 он, 2013 оны эхний 9 сарын санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

“Монгол катеринг” ХХК-тай 2012 онд хийсэн ажиллагсдын цай хоол нийлүүлэх гэрээнд ижил төрлийн ажил үйлчилгээ үзүүлж байгаа 3 компаний гэрээнд тусгагдаагүй “өдөрт нэхэмжлэх хоолны тоо 1760 байна” гэсэн нэмэлт мэдээллийг оруулан өгч, уг гэрээний дагуу ажиллагсдын хоолны картаар гарсан гүйцэтгэл, гэрээнд тусгасан 1760 хоол хоёрын зөрүү буюу ажиллагсдын идээгүй хоолны үнийг НӨАТ-ын хамт компани төлсөөр ирсэн ба 2012 он, 2013 оны 11 сар хүртэл нийт 2,591.5 сая төгрөгийг илүү төлсөн байна.

“Монгол катеринг” ХХК-тай хийсэн 9 сарын 25 –ний өдрийн нэмэлт гэрээнд:

1. Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн хооронд байгуулсан 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 5/063-12 тоот гэрээний 2.3 дугаар заалтыг үндэслэн өдрийн хоолны нэгжийн үнэ 4950 төгрөгөөр тооцож байсныг 5250 төгрөг болгож 300 төгрөгөөр, тооцож байсныг 4650 төгрөг болгон 50 төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн 2012 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн гэрээний хугацааг дуусах хүртэл мөрдөн, тооцож байхаар тогтов.
2. Үнийн өөрчлөлтөөс бусад гэрээний заалтуудад өөрчлөлт орохгүй.
3. Энэхүү нэмэлт №01 гэрээ нь 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 5/062-12 тоот гэрээний салшгүй хэсэг байна. Энэ нь үндсэн гэрээ буюу №01 гэрээний 2.2 дугаар заалтыг өөрчилсөн ба бусад заалтыг өөрчлөхгүй гэж зааж өгсөн байна.

Гэтэл Эрдэнэт ХХК –ны холбогдох албан тушаалтнууд дээрх нэмэлт гэрээг зөрчин, өөрчлөгдсөн гэрээний заалтын дагуу ажиллагсдын идээгүй хоолны үнийг НӨАТ-ын хамт Монгол катеринг ХХК-д төлж байгууллагад их хэмжээний хохирол учруулсан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...” гэж заасныг үндэслэн **АКТ ТОГТООХ НЬ:**

1. “Монгол катеринг” ХХК-д илүү төлсөн хоолны үнэ 2,591.5 сая төгрөгийг тус компаниас гаргуулан авч, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны дансанд гэрээ дуусах хугацаа буюу 2014 оны 2 дугаар сарын 30-ны дотор төвлөрүүлэх,
2. Байгууллагад хохирол учруулсан албан тушаалтнуудад хариуцлага тооцож, ?
3. Актын биелэлтийг гаргаж, 2014 оны 9 дүгээр сарын 20-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

Тогтоосон актын төлбөрийг барагдуулах ажлыг тус компанийн Ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогч захирал Б.Алтанхуяг, Ерөнхий нягтлан бодогч Платонов М.В нарт хариуцуулав.



АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН.

ЭРДЭНЭТ ҮЙЛДВӨР ХХК-НЫ
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ЭДИЙН
ЗАСАГ ХАРИУЦСАН ОРЛОГЧ
Б.АЛТАНХУЯГ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
ПЛАТОНОВ М.В

